

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 7 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

7 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд аймгийн баяр наадам зохион байгуулагдаж зургаан насны морьд уралдан, 128 бөх барилдаж, шагайн болон сур харваачид онч мэргэнээ сорьсон байна.

Аймгийн баяр наадмыг Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу Ковид -19 цар тахлын дэглэмийг чанд сахин зохион байгууллаа.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд 27 удаа фото, видео болон бичвэр бүхий мэдээ мэдээллийг нийтэлсэн. Мөн аймгийн баяр наадмын видео шторк, баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа болон үндэсний бөхийг шууд аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны нийгмийн сүлжээ болон цахим хуудсаар иргэд, олон нийтэд түгээсэн бөгөөд давхардсан тоогоор 154500 удаа үзэж байна.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд тэргүүтэй яамны газар, хэлтэс, Улсын төв эмнэлгүүдийн дарга нар 7 дугаар сарын 13-ны өдөр орон нутагт ажиллаж, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Энхтүсдэм өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчидтай уулзалт зохион байгуулсан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

7 дугаар сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 2849262.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс 3050000.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

7 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-303, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27, ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-92, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-16 бүртгэгдэн нийт хуулийн этгээд 603 болж 4.5 хувиар нэмэгдсэн.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 5135527.6 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 5670832.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд 386267.6 мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 6 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэвлэмэл байдлаар 42, цахимаар 158 иргэнд хүргэсэн.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Эрүүл мэндийн газрын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 21142.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 21025.7 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 116.8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 114215.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 111019.2 мянган төгрөгийн зөвлөмж өгч, 3196.2 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Мал эмнэлгийн газрын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 12031.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 910.3 мянган төгрөгийг холбогдох эздээр нөхөн төлүүлж орон нутгийн орлого болгуулахаар, 50.7 мянган төгрөгийг буцаан олгуулахаар нийт 961.0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон.

Нийгмийн даатгалын сангаас олгосон :Тэтгэвэр

№	Төрөл	2019.07.24		2020.07.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1699	4736247,5	1802	5403124,7	103
2	Тахир дутуу	321	526236,1	341	862832,5	20
3	Тэжээгчээ алдсан	121	255165,0	128	278087,3	7
4	Үйлдвэрийн осол	51	133063,7	27	99609,3	-24
	Нийт дүн	2192	5650712,3	2298	6643653,8	106

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2019.07.24		2020.07.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян, төг/
1	ХЧТА тэтгэмж	548	75006,6	695	94855,5
2	ЖБА тэтгэмж	169	267971,3	238	395341,6
3	Оршуулга	36	36000,0	41	41000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	7	2844,5	3	4521,5
5	Ажилгүйдэл	112	234958,7	435	281798,1
	Нийт дүн	872	616781,1	1412	817516,7

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.07.24	2020.07.24
Шинээр	109	289
Мөнгө тушаасан	575	504
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	152183,6	88792,2

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын ажлын чиглэлээр: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1327 заалт бүхий 4627 хүний нэр, 1242 байгууллагын нэр, 2915 газар зүйн нэр, 1479 хуудас баримтыг программд холбож, 458 хуудас баримтыг фотошоп программаар янзалж, 709 хуудас баримтыг скайнердсан. Архивын баримтаас 11 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -4
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -39
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо-39
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо-5
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо-3
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо -1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -23
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -27

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 4
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл -15
- Гэрээний бүртгэл -34
- Барьцааны гэрээний бүртгэл -176
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -4

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -1
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 61
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 6

Цагдаагийн хэлтэс нь: Цагдаагийн хэлтсийн Шуурхай удирдлагын тасагт 7 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 76 дуудлага, мэдээлэл ирсэн ба өмнөх оны мөн үеэс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 14-өөр буюу 87.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 2-оор буюу 4.5 хувиар, нийт гомдол мэдээлэл 16-аар буюу 26.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэв журмын эргүүлийн чиглэлийг гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Баянтал, Сүмбэр, Шивээговь сумын нутаг дэвсгэрт давхардсан тоогоор 120 алба хаагч 1632 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, зөрчил гаргасан 1536 иргэнийг эрх бүхий албан тушаалтны зүгээс 47861.500 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 67 хүнийг эрүүлжүүлэх, баривчлах, саатуулах байранд хүргэн, 6 хүнийг шүүхээр баривчлуулж, 18 жолоочийн эрхийг хассан байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Засгийн газрын 2018 оны “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 01 дүгээр албан даалгаврын дагуу Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах ерөнхий шаардлага MNS 6751:2019 стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран 7 дугаар сарын 1-ний өдөр орон нутгийн хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар Шивээговь, Баянтал, Сүмбэр сумдын 22 тоглоомын талбайн орчин, 84 тоглоомонд хяналт, шалгалт үнэлгээ хийж 2 тоглоомын талбайг ашиглах боломжгүй, 69 тоглоом эвдэрсэн хүүхэд тоглоход эрсдэлтэй гэж үнэлэгдлээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай болон Архидан согтуурахтай тэмцэх тухай, хууль, Covid-19 халдварт цар тахлын үед авах арга хэмжээний тухай аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Буудал” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, хяналт шалгалт хийхэд ямар нэг ноцтой зөрчил дутагдал илрээгүй.

Улсын хэмжээнд 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дахин зохион байгуулагдаж байгаа “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2020”, “Яараад яахав дээ аян”-ы хүрээнд Монгол даатгал ХХК, Ард даатгал ХК, Говьсүмбэр телевиз хамтран “Жолооч танд туслая” уриан дор орон нутгийн замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарын даралтыг үзэж шаардлагатай амин дэмээр хангаж ядаргааг тайлж гарын бэлэг гардуулан аяныг сурталчилан ажиллав. Мөн аяны хүрээнд “Мотоцикль, хамгаалах малгай, “Хяналт шалгалт”, “Гарцаар гарцгаая” “Бяцхан зорчигч” хэсэгчилсэн арга хэмжээг аймгийн Авто тээврийн төвтэй хамтран зохион байгуулж, тээврийн хэрэгсэл болон мотоциклийн жолооч нарт зам тээврийн осол хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж хүргүүлэн, хамгаалах малгайн ач холбогдлын талаар яриа таниулгыг хийн, нийт 170 гарын авлага, бага насны хүүхдийг замын хөдөлгөнд эрсдэлгүй тээвэрлэх, оролцуулах чиглэлээр 67 санамж, зөвлөмж иргэдэд хүргүүлсэн. Мөн сумдын малчид, отор нүүдлээр яваа мал бүхий иргэдтэй уулзаж санамж, зөвлөмж тарааж “Яараад яахав дээ” аяныг сурталчлан авто замын бүсэд малаа байнгын хариуцлагатай байлгах, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд дүрмийн дагуу оролцуулах талаар яриа таниулга хийж ажиллав.

Тайлант сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн мэдэгдэл 62, Говьсүмбэрийн телевизээр 4 нэвтрүүлэг, Цагдаагийн хэлтсийн сайтаар 6 мэдээлэл, Говьсүмбэр Цагдаагийн хэлтэс фэйсбүүк хаягаар байршуулсан постер 12, шторк 3, гарын авлага 615, санамж сэрэмжлүүлэг зөвлөмж 1050 ширхгийг иргэд олон нийтэд хүргэж мэдээ мэдээллээр ханган ажиллалаа.

Шүүхийн шинжилгээний алба: Хэргийн газрын үзлэгт 21 удаа ажилласнаас зам тээврийн ослын 5, хулгайлах гэмт хэрэг 5, хүний амь нас эрсэдсэн 3, бусад хэргийн газрын үзлэгт 8 удаа оролцсон. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин

олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 407 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги: Хүмүүжигчдийг нийгэмшүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд анхааран ажилласан бөгөөд сургалтын төлөвлөгөөний дагуу 45 хүмүүжигчид “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-иар үе шаттай сургалт зохион байгуулсан.

Тайлант сард хүмүүжигчдийн авьяас, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор шагайн харвааны дугуйланд 80, морин хуурын дугуйланд 6, даалин оёх дугуйланд 54, сагсан бөмбөгийн дугуйланд 18, гар бөмбөгийн дугуйланд 17, ширээний теннисний дугуйланд 21, Монгол бичгийн дугуйланд 16, бичиг үсгийн сургалтад 3 хүмүүжигч тус тус хамруулж байна.

Хүмүүжигчдийн дунд холын зайн шидэлт, буухиа тэмцээн, аяыг таа, та та тунга, монгол бичгээр хэн хурдан унших вэ, заавал цээжлэх 10 шүлгийн уралдаан, ширээний теннисний тэмцээнүүдийг зохион байгуулсан.

“Номтой нөхөрлөө” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 46 хоригдол номын тэмдэглэл хөтөлсөн ба “Ухаан далай номоос эхтэй” сэдэвт гар зургийн уралдаан, “Бяцхан ном” эссэ, зохион бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж идэвхтэй оролцсон хоригдлуудыг шагнаж, урамшуулсан.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран хүмүүжигчдийг бичиг баримтжуулах буюу иргэний үнэмлэх шинээр болон дахин олгох, иргэний үнэмлэхний хугацаа сунгах зэрэг зөрчилтэй 4 хүмүүжигчийг бичиг баримтжуулсан.

Тайлант сард төлбөрийн 95 гүйцэтгэх баримт бичгээс 57 гүйцэтгэх баримт бичгийн 91515.473 мянган төгрөг, 17 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 47.8 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө болон цаг үеийн нөхцөл байдал, иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу 8 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт 36, төлөвлөгөөт бус шалгалт 5, зөвлөн туслах үйлчилгээ 6, урьдчилан сэргийлэх шалгалт 4, тандалт судалгаа 1-ийг тус тус хийж, улсын байцаагчийн зөвлөмж 13, дүгнэлт 4, албан шаардлага 11, акт 1, удирдамж 5-ыг боловсруулж хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-уудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Иргэний гомдол мэдээллийн дагуу 2 газарт шалгалт хийж, 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 50000 төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан “Урьдчилан сэргийлэх хяналт хийх” тухай 01/13 тоот удирдамжаар аймаг, сумын баяр наадмын үед хоол, хүнсний үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Шалгалтын явцад давхардсан тоогоор 12 зөрчил илрүүлж, зөрчлийн 83 хувийг газар дээр нь арилгуулсан.

Шивээговь суманд үйл ажиллагаа явуулдаг Шивээ Овоо ХК-д ажлын байранд үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, холбогдох хууль эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 7 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд төлөвлөгөөт шалгалт гүйцэтгэсэн. Шалгалтаар Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур цалин хөлс олгож байгаа болон ажил албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй, зохих төлбөрийг төлөөгүй, даралтат саванд ээлжит туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгээгүй зэрэг дутагдлууд илэрч дутагдлыг арилгуулахаар 4 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Онцгой байдлын газар нь: Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль стандарт норм, нормативыг баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг зэрэг 16 аж ахуй нэгж байгууллагад хяналт шалгалт зохион байгуулан илэрсэн зөрчил дутагдалд заавар зөвлөгөө өгч гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газраас өгсөн үүргийн дагуу аймгийн үерийн эрсдэлийн үнэлгээг хийж тайланг хүргүүлсэн. Үнэлгээгээр эрсдэлийн түвшин дунд үнэлэгдсэн.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийн хүрээнд амарч, аялал зугаалгаар явж байгаа иргэдэд болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын газраас завьт эргүүлийг баяр амралтын өдрүүдэд 5 удаа хийж Хаялага нуурын эрэг дагуу амарч байгаа 1502 иргэнд усны ослоос урьдчилан сэргийлэх талаар анхааруулсан.

Улаанбаатар-Сайншанд, Сайншанд-Улаанбаатар, Бор-Өндөр-Улаанбаатар чиглэлд зорчиж буй иргэдэд Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төвтэй хамтран үер усны болон тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, 2 нэр төрлийн 1000 ширхэг гарын авлага тараасан.

Онцгой байдлын ерөнхий газар болон Ус, цаг уур орчны шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын төлөв, мэдээний дагуу үер, усны аюулаас сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг 4 удаа хүргэж, Онцгой байдлын газрын болон орон нутгийн Говьсүмбэр аймаг, Боржигин нутаг минь, Чойр зар гэсэн фэйсбүүк хаягуудад 8 удаа байршуулсан ба “Багц мессеж” үйлчилгээг ашиглан 2 удаа 643 малчид болон мал бүхий иргэдэд хүргэн ажилласан.

Тайлант сард гал түймрийн дуудлагагүй, аврах ажиллагааны 2 дуудлагаар Эрэн хайх аврах бүлэг ажилласан.

7 дугаар сарын 3-ны өдөр тарваган тахлаас урьдчилан сэргийлэх вакцинд 33 албан хаагчийг хамрууллаа.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагын явц, үр дүнгийн талаар сурагчдаас судалгаа авч, судалгааны үр дүнд анализ хийн сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд цаашид давтлагын үр дүнг сайжруулах зөвлөмжийг өгч ажилласан. Элсэлтийн ерөнхий шалгалт болон хуваарь олголтын талаар Боловсролын үнэлгээний төвийн, Монголын Их Дээд Сургуулийн комисс болон Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яамнаас өгсөн мэдээллийг сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд танилцуулах цахим хурлыг зохион байгуулж зөвлөмж өгсөн. Элсэлтийн ерөнхий шалгалтыг 2020 оны 7 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд Лаборатори 5 дугаар сургууль дээр элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Тулгар төрийн 2229, Их Монгол Улсын 814, ардын хувьсгалын 99, аймаг, сумдын хурдан морины уралдаанд хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллалаа. Аймгийн хэмжээнд нийт 273 морь уралдаж, 123 уралдаанч хүүхдийг гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулж ажилласан. Уралдааны явцад 3 хүүхэд мориноос унаж хөнгөн хэлбэрийн гэмтэл авсан бөгөөд хүүхэд тус бүрт эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсэн.

Соёл, урлагийн чиглэлээр: 6 дугаар сарын 19-ний өдрөөс 7 дугаар сарын 20-ны өдрүүдэд Энхтүсдэм өрхийн эмнэлгийн 5 албан хаагч болон 5 үйлчлүүлэгчид, Балданзасаг худалдааны төвийн 18 ажилтан, Цахилгаан түгээх сүлжээний 48 албан хаагчид явуулын VR BOX соёлын үйлчилгээ үзүүлж, нийт 76 иргэнд соёлын үйлчилгээ үзүүллээ. Танхимаар 80 иргэн үйлчлүүлж 80.000 төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

“Монгол тоглоом наадгай” тэмцээнийг төрийн байгууллагуудын албан хаагчдын дунд халз харваа, үйчүүр, шагай шүүрэх төрлүүдээр зохион байгуулсан. Тэмцээнд төрийн байгууллагын 105 албан хаагч оролцсон.

Төмөр замын байгууллагуудын дунд "Боржигин тоглоом наадгай" тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд Төмөр замын байгууллагуудын 102 албан хаагч оролцсон.

Монгол тоглоом наадгай, Боржигин тоглоом наадгайг иргэдэд зааж сургах, хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах зорилгоор Халз харваа, Аргай тонгорох, Шагай шүүрэх, Үйчүүр зэрэг тоглоомуудыг 207 иргэнд зааж сурган түгээн дэлгэрүүлсэн.

Угийн бичиг хөтлөх арга зүйн сургалтыг зохион байгуулж, аймгийн Эрүүл мэндийн газрын 14 албан хаагч хамрагдсан.

Чулуун өв соёл үндэсний хөтөлбөрийн хүрээнд 7 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд 2019 онд бүртгэгдэн судалгааны эргэлтэнд оруулсан Мааний үсэгтэй хад, Хүүхдийн цагаан овоо зэрэг чулуун өв соёлын тайлбарыг цахим хуудсанд байршуулан, 71 иргэнийг мэдээллээр ханган чулуун өв соёлыг сурталчилан таниулсан.

Номын сан: Уншлагын танхимаар 21 уншигчид 59 төрлийн ном, Гэрээр 4 уншигчид 7 төрлийн ном, зөврөөр 8 уншигчид 18 төрлийн номоор, нийт 33 иргэнд 84 төрлийн номоор тус тус үйлчиллээ.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Спортын секц дугуйлан, уралдаан тэмцээн түр хаагдсантай холбоотой 11 төрлийн тэмцээнийг цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Өглөөний гүйлт, дасгалд давхардсан тоогоор 240 иргэн хамрагдаж, иргэдийн идэвхитэй оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 1.0 сая төгрөгийн спортын хэрэгсэл, витамин, амны хаалтаар урамшуулсан.

Эрүүл мэндийн талаар: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2019 оны 7 сар	2020 оны 7 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	254	246
Гэрийн төрөлт	1	0
Амьд төрсөн хүүхэд	255	249
Амьгүй төрөлт	3	0
Нас баралт	31	41
Эмнэлгийн нас баралт	7	2
Хоног болоогүй нас баралт	3	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	4	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	2864	2475
Амбулаторийн үзлэг	55020	46176
Халдварт өвчин	110	60

Улсын Их хурлын гишүүн С.Батболд аймгийн Нэгдсэн эмнэлэгт орчин үеийн тоноглол бүхий түргэн тусламжийн автомашиныг гардуулан өгсөн.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд 24 цагаар үүрэг гүйцэтгэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас Сүмбэр сумын цагдаагийн хяналтын цэгээр дайран өнгөрсөн автомашины 2236 зорчигчид тандалт хийхэд, коронавирусын халдварын сэжигтэй тохиолдол илрээгүй.

Дэлхийн банкнаас “Эрүүл мэндийн хөгжлийн хөтөлбөр” төслийн хүрээнд 13 нэр төрлийн аппарат багаж хэрэгсэлтэй, бүрэн засварын ажилтай ариутгалын төвийг байгуулахаар төслийн инженер техникийн ажилтан, архитекторч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тархвар судлаач нар 7 дугаар сарын 2-ны өдөр орон нутаг ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: “Монголын үндэсний экспорт, импортыг дэмжих үндэсний төв”-ийн дэргэдэх Потеншил сургалтын төвтэй хамтран ажилгүй, ажилгүйдэлд өртөж болзошгүй 13 иргэнд хангамжийн нярав, 18 иргэнд үсчний мэргэжил олгох сургалтыг тус тус зохион байгуулан 4600.0 мянган төгрөгийг зарцуулж, хувиараа бизнес эрхлэх болон ажилд зуучлагдах боломжийг бий болгосон.

2019 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийн дэмжлэгт хамрагдсан 9 бүлгийн төслийн хэрэгжилтэд хяналт хийж, үйл ажиллагааг нь доголдсон 3 бүлэгт цаашид тогтвортой хэвийн үйл ажиллагаагаа явуулах талаар заавар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: “Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажил зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/127 дугаар захирамжийн хэрэгжилтийг шалгах, технологит ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавих чиглэлээр 2020 оны 7 дугаар сарын 5-10-ны өдрүүдэд Цөм сүрэг үржлийн төвд хяналт шалгалт хийсэн. Уг хяналтаар Сүмбэр үүлдрийн 910 хонинд ангилалт хийсэн ажлыг хянан баталгаажуулахад каракуль үүлдрийн 103 хонь, 67 хуц бүртгэгдсэнийг хасаж, Сүмбэр үүлдрийн 740 хонинд ангилалт хийсэн байна. Удам зүйн үнэлгээний программыг Цөм сүрэг үржлийн төвд нэвтрүүлэх зөвлөмжийг өглөө.

Малын бүртгэл мэдээллийн цахим санд 2010-2015 оны хооронд бүртгэсэн малаас эдийн засгийн эргэлтэд оруулсан, хорогдсон 11249 малыг хасч, 588 малыг шинээр бүртгэв.

2020 оны 7 дугаар 4-ний өдрийн байдлаар төллөвөл зохих 183675 эх малаас 170483 эх мал төллөж, 170819 төл гарсан. Үүнээс бойжиж байгаа төл 162017, мал төллөлт 92.8 хувь, төл бойжилт 94.8 хувь, төлийн хорогдол 8010, том малын хорогдол 8263 байна.

2020 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 31 иргэн, 1 аж ахуйн нэгж 4 байгууллага 17.5 га талбайд төмс, 19.4 га талбайд хүнсний ногоо, 6 га талбайд тэжээлийн ургамал, 0.56 га талбайд жимс, жимсгэнэ, нийт 43.46 га-д тариалалт хийж, төлөвлөгөө 91.5 хувьтай байна. Тариалалтын ажилд зүтгэх хүчний 2 трактор, чиргүүл дүүжин машины хамт, бага оврын 2 тракторыг иж бүрдлийн хамт ашиглан тариалалтын ажлыг гүйцэтгэв. Сүмбэр сумын 1 иргэн ногоон тэжээл тариалах санаачилга гарган, шинээр 4 га талбайд тариалалт хийгээд байна.

Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Ахуйн үйлчилгээний нэгдсэн холбоотой хамтран “Ахуй үйлчилгээний салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх” зорилгоор 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрөөс 7 дугаар сарын 17-ны өдрүүдэд үсчний мэргэжил олгох сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад орон нутгийн 18 үсчин хамрагдан ур чадвараа дээшлүүлэн, мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд нийт 3.3 тэр бум төгрөгийн 21 төсөл хүлээн авч, дүгнэн 70 онооноос дээш үнэлгээтэй 15 төслийг дараагийн шатны шалгаруулалтад шилжүүлээд байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 7 дугаар сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй үхрийн /ястай/ махны үнэ 800 төгрөгөөр, хонины мах /цул/ 800 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-250 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	Ястай	11000	9500	+800
		Цул	12000	11000	-
2	Хонины мах	Ястай	9500	8000	
		Цул	10000	10000	+800
3	Адууны мах	Ястай	8500	7500	
		Цул	9000	9000	+500
4	Ямааны мах	Ястай	7000	6000	
		цул	9000	9000	+500
5	Тахианы мах	Гуя	10500	10000	
		мөч	9800	9000	
6	Лууван	монгол	2000	1200	-
		хятад			
7	Төмс	монгол	1250	850	+250
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1200	
		хятад			-
9	Чинжүү	монгол			-
		хятад	6500	5500	
10	Манжин	монгол	3800	3200	+50
		хятад			-
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3000	2500	-
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	монгол	6000	5500	-
13	Өргөст хэмх	монгол	8000	6500	-

14	Элсэн чихэр	монгол	2100	1600	-
15	Будаа	Цагаан задгай кг	2500	2200	+100
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	Задгай	2500	2000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	3050	-
17	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	750	-
19	Өндөг	ОХУ	400	330	-
		Монгол	400	300	-
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	+250
		Задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан /дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
21	Ургамлын тос	Олейна	5500	4800	+50
		Алтан	3800	3600	-
22	Гоймон	Алейка	1800	1600	-
		А/тариа савхан	1100	950	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: “Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 1 уст цэг байгуулах ажил”-ын тендерт “Ус Ундрах” ХХК шалгарч гэрээ байгуулан улсын төсвийн 29.6 сая төгрөгийн хөрөнгөөр Сүмбэр сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар гүний худаг гаргах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сумдын байгаль хамгаалагчдаар дамжуулан сумдын Засаг даргын Тамгын газар, Уулзварын гол нөхөрлөлтэй хамтарч Уулзварын гол, Дунд уул, Дарь эх, Цоорхойн рашаан, Хүрийн ногоо, Хаялага нуурын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 12.5 тонн хог хаягдал цэвэрлэсэн. Мөн үерт автсан Уулзварыг гол, Цоорхойн рашааны хамгаалалтын хашааг сэргээж зассан.

Баяр наадмын өдрүүдээр Уулзварын гол, Цагаан Дарь эх, Асгана булаг, Элст ам, тусгай хамгаалалттай бүсийн зүүн, баруун хажуу, Цоорхойн рашаан орчимд Тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч эргүүл, шалгалтаар ажиллаж аялагч нарт санамж, зөвлөмж өгч ажилласан. Нийт баяр наадмын өдрүүдээр тусгай хамгаалалттай бүсэд 433 хүн нэвтэрсэн байна.

Тарвага сэргээн нутагшуулах ажлын хүрээнд “Амьтан хамгаалах сан” ТББ, тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч, “Уулзварын гол” иргэдийн нөхөрлөлийн гишүүд мониторингийн судалгаа хийсэн. Ажиглалт судалгаагаар сэргээн нутагшуулсан болон хуучин тарвага бүхий нутагт 107 тарвага тоологдсон байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын хүрээнд: Энэ сард Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөс 8 хугацааны мэдээ, нийт 248, климат агро дундаж мэдээ, Хөдөө, аж ахуйн тойм, 10 хоногийн тойм мэдээ, нийт 3 сарын тойм мэдээг 1 удаа тус тус дамжуулсан.

Цаг агаарын нарийвчилсан урьдчилсан мэдээ өглөө 8 цаг 30 минутаас өмнө, нэг хоногийн урьдчилсан мэдээг 14 цагаас өмнө, 5 хоногийн урьдчилсан мэдээг 16 цагаас өмнө сервэрт байршуулж, <http://govisumber.tsag-agaar.gov.mn> цахим хуудсанд нарийвчилсан болон хоногийн тойм мэдээг 9 цаг 30 минутын дотор, 1-5 хоногийн урьчилсан мэдээг 14 цаг 30

минутын дотор, 7 хоногийн төлөв, 7 хоногийн тойм мэдээг даваа гариг бүр, сарын урьдчилсан мэдээг 25-ны өдрийн дотор, сарын тойм мэдээг 5-ны өдрийн дотор тус тус веб сайтанд байршуулж ажиллалаа.

7 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар цаг уурын тойм мэдээ: 02, 03, 04, 05, 07, 08, 09, 10, 13, 16-ны өдрүүдэд бороо орж 30.8 мм тунадас унасан. Салхи ихэнхи хугацаанд 7-12 м/сек, зарим үед 13-15 м/сек хүрч салхилсан. Агаарын дундаж температур 20.1 градус дулаан, хамгийн хүйтэн нь 18-ны шөнө 7.7 градус дулаан, хамгийн дулаан нь 15-ны өдөр 33.5 градус дулаан байсан.

7 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар хөдөө аж ахуйн цаг уурын тойм мэдээ: Бэлчээрийн нийт ургамлын ургалт сайн, бэлчээрийн ургамлын ажиглалтын төлөөлөх ургамал болох хялганад залаалалт, хөмүүлд цэцэглэлтийн үе шат хашаалсан ба хашаалаагүй талбайд явагдаж байна. Ургамлын дундаж өндөр 15 см байна. Бэлчээрийн ургамлын хөнөөлт хортон мэрэгчдийн ажиглалтаар авгалдай, бие гүйцсэн царцаа ажиглагдаагүй. Мал аж ахуйд зохиогдож байгаа ажил, малын бэлчээрлэлтэнд цаг агаарын байдал хэвийн ажил саатаагүй. Бог, бод малын тарга хүч сайн, худгийн болон тогтоол усаар ундаалж байна.

Энэ сард азотын давхар исэл (NO₂) болон хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаагийн давтамжтайгаар сорьцыг 30 удаа, мөн шинжилгээг 11 удаа, 7 дугаар сарын 1-ний өдрөөс 17-ны өдрүүдэд дээжинд шинжилгээ хийсэн дундаж азотын давхар исэл (NO₂) 0.016 мкг/мг сарын хүлцэх агууламжийн хэмжээ 0.050 мкг/мг, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.008 мкг/мг, сарын хүлцэх агууламжийн хэмжээ 0.050 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн Засаг даргын захирамжаар 2011-2020 онд газар эзэмших, ашиглах эрхийг дуусгавар болгосон 43 хувийн хэргийг цахим архив үүсгэн архивлан ажиллаж байгаа бөгөөд аймгийн Засаг даргын захирамжаар газар эзэмшиж, ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг нарийвчлан гаргахаар ажиллаж байна.

“Үндэсний хэмжээний газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийн үнэлгээ” хийх ажлын хүрээнд 2 удаагийн “Openforis, Collect earth” программын онлайн сургалтанд хамрагдан аймаг тус бүрт үнэлгээ хийх цэгүүдийг хуваарилан өгсний дагуу 5203 цэгээс 838 цэг дээр үнэлгээ хийж ажилласан.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 6 байршилд газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулах тухай зар мэдээллийг газрын цахим бирж болон өнөөдөр сонинд зарыг байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Геодезийн цэг тэмдэгтийн тооллогын ажлын хүрээнд Шивээговь, Баянтал, Сүмбэр сумын нутагт дэвсгэрт тооллогыг зохион байгууллаа. Тооллогоор 80 цэг тэмдэгтийг газар дээр нь явж бүртгэл хийсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 75 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 60 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 55 хувьтай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 35 хувьтай, Сүмбэр сум 2 дугаар багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 80 хувьтай, Чойрын хийдийн гол Дуганы барилга 75 хувьтай, аймгийн төвийн авто замын ажил 80 хувьтай, аймгийн төвийн гэрэлтүүлгийн ажил 80 хувьтай тус тус хийгдэж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 60 хувьтай хийгдэж байгаа бөгөөд Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж буй Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэгийн их засварын ажил 60 хувьтай тус тус хийгдэж байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Найрамдал хотхоны өргөх станцын барилгын ажил 55 хувьтай, Сүмбэр сумын 2, 3-р багт тоглоомын талбай байгуулах ажил 45 хувьтай, Гомбосүрэн ноёны нэрэмжит талбайн тохижилтын ажил 60 хувьтай тус тус хийгдэж байгаа бөгөөд Сүмбэр сумын 6 дугаар байрны фасад засварын ажил дуусч, улсын комисс ажиллуулахаар хүлээгдэж байна.

Тээвэр, авто замын талаар: Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 485, өссөн дүнгээр 5224 тээврийн хэрэгсэл хамрагдахаас 5917 тээврийн хэрэгсэл хамрагдаж гүйцэтгэл 114 хувьтай байна

Тайлант хугацаанд хот хооронд 356 иргэн зорчиж, 46 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачааны дагалдах бичиг 1200, ачаа тээвэрлэлтийн 1400 замын хуудас замын хуудас олгосон байна.

Худалдан авах ажиллагааны талаар:

Улсын төсвийн хөрөнгөөр 9 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 7 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар 7 ажлын тендер шалгаруулалтыг зарласнаас 4 бараа ажил үйлчилгээний ажил дуусч, 3 бараа ажил үйлчилгээ хийгдэж байгаа, 2 ажлыг зарлаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 14 ажлын тендер шалгаруулалтыг зарласнаас 6 бараа ажил үйлчилгээний ажил дуусч, 9 бараа ажил үйлчилгээ хийгдэж байгаа, 1 ажлын тендер шалгаруулалтыг зарлах хугацаа болоогүй байна.

Авто замын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаар 7 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгүүлж байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn govisumber.gov.mm сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтын үр дүнг цахимаар мэдээлж байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: “COVID-19” өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагуудын өрөө тасалгаанууд болон техник хэрэгсэл, тоглоомуудад ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжилтийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Сумын ОНХСангийн 2020 оны төлөвлөгөөний дагуу “Жижиг тэрэг худалдан авах” бараа нийлүүлэх гэрээг 13,500,000 төгрөгөөр “Очирт хөрс” ХХКомпанитай байгуулж 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдөр хүлээн авлаа.

Сумын баяр наадмыг 2020 оны 7 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан. Баяр наадмын өдрүүд болон олон хоногийн амралтын үеэр үер усны аюулаас сэрэмжлүүлэх мэдээллийг сумын удирдах ажилтнуудын шуурхай болон цахим хуудсаар иргэдэд хүргэн ажилласан.

Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг Шилийн мөг хэмээх газарт 3 м гүнтэй нүх ухаж хлорын шохойгоор халдваргүйтгэж 724 толгой малын сэг зэмийг булж устгасан. Сэг зэм цуглуулах, булах ажилд сумын мэргэжлийн ангиас 12 хүн, малчидтай хамтран ажилласан.

Шивээговь сум: Сумын баяр наадмыг 7 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж гурван насны морь уралдаж сур, шагайн харваачид онч мэргэнээ сорьсон.

Шивээговь сумын баяр наадмын үеэр коронавирусууд урьдчилан сэргийлж 28900 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж, наадмын цэнгэлдэх хүрээлэнгийн 2 талын хаалган дээр Эрүүл мэндийн төвийн ажилчдыг ажиллуулж цэнгэлдэх хүрээлэнд орсон үзэгчдийн халууныг үзэж, гарыг ариутган амны хаалтыг 300 гаруй иргэнд олгож ажилласан. Мөн хүндэтгэлийн нэг гэр, худалдаа үйлчилгээний 3 цэгийг ажиллуулж ариутгал халдваргүйтгэлийн дэглэмийг сахин ажилласан.

“Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг дээшлүүлэх” сумын дэд хөтөлбөрийн хүрээнд суманд “Төрийн үйлчилгээний төв” байгуулах засвар, тохижилтын ажлыг “Оч хийц” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 9,8 сая төгрөгийн гэрээг байгуулаад байна.

Сум хөгжүүлэх сангийн зөвлөлийн хурлыг 2020 оны 7 дугаар сарын 8-ны өдөр зохион байгуулж, 19 төсөл хүлээн авснаас 12 төслийг сонгон шалгаруулж, 90.0 сая төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.

Суманд төрийн үйлчилгээний операторын системийг шинээр нэвтэрүүлж төрийн 5 байгууллагын 52 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг иргэдэд олгож байна. 2020 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 48 иргэнд үйлчлээд байна.

Суманд наториатын үйлчилгээг иргэдэд үзүүлж 7 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 149 иргэнд үйлчилгээг үзүүлж 304540 төгрөгийн орлогыг сумын тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлсэн байна.

Ховд аймгийн тарваган тахлын сэжигтэй 2 тохиолдлын онош батлагдсан тул зорилтот бүлгийн 30 албан хаагчид тарваган тахлаас урьдчилан сэргийлэх вакциныг хийж, сэрэмжлүүлэг мэдээллийг албан байгууллага ААН-д албан тоотоор хүргүүлсэн байна. Мөн байгууллагын цахим хаягаар олон нийтэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ажлыг эрчимжүүлж үйлчилгээний газрууд болон айл өрхүүдээр явж давхардсан тоогоор 172 иргэнд үзлэг шинжилгээг хийсэн.

Сумын байгаль орчин, эрүүл ахуй, орчины бохирдлыг бууруулах – Хоггүй сум дэд хөтөлбөрийн 2,4 сая төгрөгийн хөрөнгөөр сумын цэцэрлэгт хүрээлэнгийн усалгааны системийг шинэчлэх ажилд нийт 12 нэр төрлийн тоног төхөөрөмжийг худалдан авч, усалтын системийг засварлан усалгаа арчилгааны ажлыг тогтмолжуулаад байна.

Аялал жуулчлалын бүс Хаялага нуурын эргийн цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж нийт 9 тонн хог хаягдлыг цэвэрлэсэн.

Сүмбэр сум: Дэлхийн Зөн Олон улсын байгууллагын Бор-Өндөр-1 Орон нутгийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй малжуулах төсөлд зорилтот бүлгийн 15 иргэнийг хамрууллаа.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 24 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажил зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу гарын авлага бэлтгэн зөвлөмж хүргэж ажиллалаа.

Хонины ноосны хэмжилт хийхэд Сүмбэр үүлдрийн эм хонь 1.5 кг, төлөг 1.1-1.3 кг, бүдүүн хуц 2.0 кг, Цэвэр каракуль хуц 2.5 кг, эм хонь 1.9- 2.3 кг, монгол эр хонь 1.5 кг, эм хонь 1.4 кг, төлөг 1.0-1.2 кг, сумын дүнгээр хонины ноосны дундаж 1.7 кг байна.

Тэмээний ноосны хэмжилт хийхэд: буур эр ноос 3.4 кг, эм ноос 4.8 кг, ат эр ноос 3.5 кг, эм ноос 4.6 кг, ингэ эр ноос 2.6 кг, эм ноос 3.4 – 4.2 кг, өсвөр эр ноос 1.8-2.0 кг, эм ноос 3.0-3.1 кг, сумын дүнгээр тэмээний ноосны гарц 7.1 кг дундажтай байна.

Нийтийн эзэмшлийн орон сууцнууд дунд хог хаягдал ангилан ялгах хогийн сав нийлүүлэх ажлын тендерийг 7 дугаар сарын 9-ний өдрөөс 21-ний өдрийн хооронд цахим хэлбэрээр зарласан.

2020 оны 6 дугаар сарын 29-нд Сумын нутаг дэвсгэрийн Байгаль хамгаалах хөтөлбөр арга хэмжээний “Тусгай хамгаалалттай газар нутагт тохижилтын ажил хийх” ажлын санхүүжилтээс 300000 /гурван зуун мянган/ төгрөгийн зардлаар иргэдэд тусгай хамгаалалттай газарт нэвтрэх тасалбар, танилцуулах самбар байршуулах ажлыг хийж гүйцэтгэлээ.